



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 71 68, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrtд.gov.mn,
Цахим хуудас: www.mrtд.gov.mn

2023. 04.26 № 02/1904

танай _____-ны № _____-т

“МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, “ГТХЗНТ”
УТҮГ, “ИНЕГ”, “МИАТ” ТӨХК, “АТҮТ”
ТӨҮГ, “ЗТХТ” ТӨҮГ, “ДЗ” УТҮГ,
“НЬО УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ
ЭЙРПОРТ” ХХК-ИЙН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх
тухай

Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар тус салбарт сүүлийн жилүүдэд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн талаар мэдээлэл хийж, урьдчилан сэргийлэх, ослын мөрөөр дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн. Үүнд:

1.1.Зам, тээврийн салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн ХАБЭА-н бүтэц, бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалтыг холбогдох шийдвэрт нийцүүлэх, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага манлайлж ажиллах;

1.2.Аж ахуйн нэгж, байгууллага бүр ХАБЭА-н хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг төлөвлөн, зориулалтаар зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих;

1.3.Аж ахуйн нэгж, байгууллагыг ХАБЭА-н дотоод хяналт буюу 2-3 шатны хяналтын үзлэгийг тогтмол хийж хэвшүүлэх, үзлэгийн үр дүнг чанаржуулах;

1.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийн тайлан, мэдээг сар бүрийн 10-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн яаманд ирүүлж, мэдээллийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны тоон судалгаатай уялдуулан, дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулах;

1.5.ХАБЭА-н хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрөл түүнтэй адилтгах гэрчилгээ зэргийг цуцлах чиглэлээр ҮЭ-ийн байгууллага манлайлан, хамтран ажиллах;

1.6.Байгууллагын удирдах ажилтан болон ХАБЭА ажилтан нийт албан хаагчийн ажлын байран дээрх ур чадвар, мэдлэг, туршлагыг сайжруулах чиглэлээр ҮЭ-ийн байгууллагатай хамтарсан сургалт, хэлэлцүүлгийг 2023 оны 2 дугаар улиралд зохион байгуулах;

1.7.Салбар хорооны бүрэлдэхүүн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаа, хурлын шийдвэрийн хэрэгжилт, тайлантай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

1.8.Салбар хорооны бүрэлдэхүүн байгууллагын үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх комиссын бүтэц, бүрэлдэхүүн холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа эсэх, үйл ажиллагаа, хурлын шийдвэрийн хэрэгжилт, тайлантай танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

1.9.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалтад орсон бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг ХАБЭА-н тухай хуультай уялдуулж, нэгдсэн бодлогоор хяналт тавих;

1.10.Салбар хорооны бүрэлдэхүүн зам, тээврийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажлын байрны судалгааг хийж, яаманд ирүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж, ХНХЯ-д уламжлах саналыг нэгтгэн боловсруулах;

1.11.Байгууллагын удирдлага, нийт ажилтан, ХАБЭА ажилтан сургалтад хамрагдсан эсэхэд хяналт тавих, Зам, тээврийн салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ХАБЭА-н сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөрт санал тусгах, сургалтын чанарыг сайжруулах зэрэг ажлыг хэрэгжүүлэн, тайланг энэ оны эхний хагас, бүтэн жилээр ирүүлэх.

ДЭД САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНЫ
ДАРГА П.ХАЛТАР

